ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар 07/02 Сайншанд

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Орлогч дарга: Сумын Засаг дарга
Гишүүдэд: Засаг даргын орлогч
Засаг даргын Тамгын газрын дарга
Сайншанд багийн Засаг дарга
Хоолт багийн Засаг дарга
Бүйлсэн багийн Засаг дарга
Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Соёлын төвийн эрхлэгч
Цэцэрлэгийн эрхлэгч
Дэмд-Од орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал
Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан
Засаг даргын Тамгын газрын байгаль хамгаалагч
Засаг даргын Тамгын газрын Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
Засаг даргын Тамгын газрын Залуучууд хөгжлийн төвийн ажилтан
Ерөнхий боловсролын сургуулийн Насан туршийн боловсролын багш
Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан
Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын

4626130015

хамгаалалтын захиргааны Ирвэс хэсгийн ахлагч
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбооны тэргүүн
Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
Хэсгийн цагдаа
Нарийн бичгийн дарга: Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн
дарга

2. Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, ажлын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж ажиллахыг Салбар зөвлөлд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

4. Зөвлөл шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 3/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ч.ОГТБИШ